

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Өвгөн	Дугаар	L361
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Сайхан- Овоо сум
Төрсөн газар	Сайхан- Овоо сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Барь ламын хийд	Сүм хийдийн дугаар	ДУСО 014
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Энхбаяр

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Барь ламын хийд

Энхбаяр: Та энэ Барь ламын хийд хэдэн ламтай хэдэн дугантай байсан түүхээс ярьж өгнө үү?

Өвгөн: За манай энэ хийд эртний юм гэнэ лээ. Би өмнөх түүхийг нь мэдэхгүй ээ. Хүүхэд байхдаа нагац лам ахыгаа бараадаж Төвд ном заалган энэ хийдэд тав зургаан жил болсон юм. Зүүн тавь гаруй, хоёр зуу шахам ламтай, маш их хурал хурдаг. Өвлийн адаг сар, хаврын эхэн сард бүр өдөр шөнгүй хурдаг сайхан хийд байсан юм. Намрын эхэн сард майдар хурдаг, тэгээд лам нарынх нь орон гэр хийдээ тойроод байдаг газар байж.

Энхбаяр: Хэдэн дугантай байсан юм бол?

Өвгөн: Цогчин дуган, жудийн дуган, мамбын дацан, ёга дацан, жанрайсигийн дуган, дүйнхор, чойрын дацан байсан.

Энхбаяр: Янз бүрийн дамжаа барьдаг байсан уу?

Өвгөн: Гэвшийн дамжаа л барьдаг байсан байх.

Энхбаяр: Энэ хийдийг тойроод суварга том хүрднүүд байсан л биз дээ?

Өвгөн: Өө зөндөө л байсан биз дээ, яг тоог нь мэдэхгүй байна.

Энхбаяр: Барь ламын хийдийн Төвд нэр нь юу гэж байсан бэ?

Өвгөн: Гүндүжанлайлин гэж байсан юм.

Энхбаяр: Таныг бага байхад хийдийн хамгийн сүүлчийн хамба ямар хүн байсан бэ?

Өвгөн: Ёнзон багш гэж хүн байсан юм.

Энхбаяр: Энэ хүн Төвд хүн үү?

Өвгөн: Өө монгол монгол. Энэ манай нутгийн хүн.

Энхбаяр: Та энэ Барь ламын хийдийн сүм дуганыг хаагдсан нураагдсан тухай ярьж өгнө үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өвгөн: Би хийдэд арав гаран настай очоод дөрөв таван жил суугаад байхад нэг хавар гэнэтхэн лам нарыг заримыг нь бариад заримыг нь хүчээр тараагаад хийд орныг хаачихсан. Би хорин онд төрсөн гэж явдаг болохоор энэ хэдэн онд болж байна.

Энхбаяр: Энэ та арав гаран настай хийдэд шавилсан. Дөрөв таван жил шавилж суусан гэхээр 1935, 1936 оны үе юм уу даа.

Өвгөн: Тэр тийм болох байх. Тэгээд мөн дөрөв таван жил сүм дуган эзгүй байж байгаад нөгөө их дайны жил юу ч үгүй нураагаад энэ сүм руу тэмээ, үхэр тэргээр ачаад явчихсан юм.

Энхбаяр: Та Барь ламын хийдийг сэргээсэн тухайгаа ярьж өгнө үү?

Өвгөн: Арав гаруй жилийн тэртээ нэг арваад багачуудтай сэргээж эхэлж оролдсон юм. Тэгээд бие хүчрэхээ байгаад энэ сүүлчийн лам нарт залгуулсан.

Энхбаяр: За гялайлаа.